• PE400*600 маркийн хацарт бутлуур 2 ш	• Ф1.5*14 төвдөө хөтлүүртэй өтгөрүүлэгч 2 ш
• PVD-900 маркийн конусан бутлуур 2 ш	• 2PNL маркийн динамик насос 2 ш
• SZZ1500*3000 чичиргээт шигшүүр 2 ш	• ЭЦБ6-10-185 маркийн динамик насос 7 ш
• TD75-650 маркийн туузан конвейер 6 ш	• YX3-200L-4M маркийн динамик насос 6 ш
• TD75-500 маркийн туузан конвейер 3 ш	• LDA-3 маркийн дүүжин кран 6 ш

Баяжуулах үйлдвэр нь уурхайгаас тээвэрлэгдэн ирсэн хүдрийг жигжигрүүлэн буталж, нунтаглан, хөвүүлэн баяжуулалт хийсний дараагаар ангилан өтгөрүүлж бэлдсэний үндсэн дээр хүдрээс жоншны баяжмал ялган авах технологитой.

Хайлуур жонш баяжуулах үйлдвэр нь анх 2008 онд жилд 150.0 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтайгаар ашиглалтад орсон бөгөөд 2013 онд үйлдвэрээ өргөтгөн 2 шугамтай болгож, жилд 300.0 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай болсон.

Баяжуулах үйлдвэрт 2022 онд 65 хүн хоногт 2 ээлжээр 20 цаг, үйлдвэрийг жилд 60 хоног ажиллуулна. Баяжуулах үйлдвэр 2 шугам (тус бүр нь 150.0 мян.тн/жил-ийн хүчин чадалтай зэрэгцээ 2 баяжуулах үйлдвэр)-тай ба нийлбэр хүчин чадал нь 300.0 мян.тн/жил буюу 51.44 тн/цаг (2022 оны АҮАТ 22х).

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ

2022 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 10.0 мян.тн жоншны хүдрийг баяжуулж, ФФ-97 маркийн 3.1 мян.тн жоншны баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөсөн.

Биологийн нөхөн сэргээлт хийж ургамалжуулах ажлыг 0.4 га-д хийж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 3-4 настай хайлаасны суулгац 500 ш-ийг орон нутгаас зөвлөсний дагуу үйлдвэрийн хашаанд тарина.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:

Унд, ахуйн усыг Даланжаргалан сумын төвийн худгаас зөөврөөр, технологийн хэрэгцээний усыг өөрийн эзэмшлийн баяжуулах үйлдвэрийн ашиглалтын талбайд гаргасан өрөмдмөл 6 худгаас хангадаг.

"Монгол-Ус" Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2020.01.06-ны өдрийн 1/06 дугаартай усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах усыг өөрийн эзэмшлийн 22.2 л/с буюу 1,918.08 м³/хон ундаргатай 6 худгаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна гэсэн. Унд, ахуйд хоногт 16.1 м³ ус ашиглана.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:

Хаягдлын сангийн засвар, өргөтгөлийн ажлын зураг төслийг 2019 онд "Престиж Инженеринг" ХХК-иар гүйцэтгүүлж, зураг төслийн дагуу өргөтгөлийн ажлыг хийлгэсэн.

Хаягдлын сан нь баяжуулах үйлдвэрээс зүүн урагш 350 м зайд байрлах ба хаягдлын сан 2 (тунаах сан), хаягдлын сан 1 (эргэлтийн усан сан) гэсэн 2 сангаас бүрдэнэ. Хаягдлын сангийн боломжит эзлэхүүн 2022 онд 234,828 м³ байгаа. Хаягдлын сан 2 (тунаах сан)-д тунасан булиндын ус өөрийн урсгалаар урсан сангийн зүүн талд байрлах эргэлтийн усан санд хуримтлагдана. Эргэлтийн усан сангийн эзлэхүүн 60.0 мян.м³ (150х200х2м).

Бага оврын 0.7 МВт хүчин чадалтай 2 уурын зуухтай.

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

№	Уртраг	Өргөрөг	Ундарга (л/с)	Насосны марк	Тоолуурын	
					Марк	Дугаар
1	109°05'09"	45°55'54"	3.0	ЭЦБ6-6.5-12.0	LXLC	202000928
2	109°05'49"	45°55'19"	4.8	ЭЦБ6-10-185		202000929
3	109°05'20"	45°55'31"	3.0	ЭЦБ6-6.5-12.0		202000919
4	109°05'28"	45°55'43"	3.2	ЭЦБ6-10-185		202000933
5	109°05'23"	45°55'48"	4.2	ЭЦБ6-10-185		202000912
6	109°05'22"	45°55'57"	4.0	ЭЦБ6-10-185		202000902



$(9,100.0 + 10,000.0) \text{ м}^2 \times 2.0 \text{ л/м}^2 \times 60 \text{ хон} =$ 2,292.0 м³/жил	- Зам болон үйлдвэрийн орчны хүдэр буулгаж, ачих талбайн тоосжилт дарахад ашиглах ус (БОННУТ 42х)
$4,000.0 \text{ м}^2 \times 4.0 \text{ л/м}^2 \times 60 \text{ хон} =$ 960.0 м³/жил	- Биологийн нөхөн сэргээлт хийж ургамалжуулахад ашиглах ус (2022 оны АҮАТ 41х)
$500 \text{ ш} \times 40.0 \text{ л/м}^2 \times 9 \text{ удаа} =$ 180.0 м³/жил	- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах ус

16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу унд, ахуйн зориулалтаар ашиглах **585.0 м³/жил** усыг төлбөрөөс чөлөөлнө.

Ашигт малтмал баяжуулахад ашиглах **10,500.0 м³/жил**, эрчим хүч (дулаан) үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглах **728.2 м³/жил**, зам, талбайн тоосжилт дарахад ашиглах **2,292.0 м³/жил**, биологийн нөхөн сэргээлт, мод тарихад ашиглах **1,140.0 м³/жил** газрын доорх усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолд заасан суурь үнэлгээ, 2013 оны 326, 327 дугаар тогтоолд заасан усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүрийг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Хайлуур жонш баяжуулахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 3,700.0 \text{ төг/м}^3 \times 0.20 \times 1.6 = 1,184.0 \text{ төг/м}^3$$

3,700.0 төг/м³: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;

20%: 326-р тогтоолын 7.б)-д заасан хайлуур жонш баяжуулахад газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь;

1.6: 327-р тогтоолд заасан Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хайлуур жонш баяжуулахад газрын доорх ус ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр.

$$10,500.0 \text{ м}^3 \times 1,184.0 \text{ төг/м}^3 = 12,432,000.0 \text{ төг}$$

Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 3,700.0 \text{ төг/м}^3 \times 0.15 \times 0.1 = 55.5 \text{ төг/м}^3$$

3,700.0 төг/м³: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;

15%: 326-р тогтоолын 8-д заасан эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь;

0.1: 327-р тогтоолд заасан Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хайлуур жонш баяжуулахад газрын доорх ус ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр.

$$728.2 \text{ м}^3 \times 55.5 \text{ төг/м}^3 = 40,422.85 \text{ төг}$$

Зам, талбайн тоосжилт дарахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 3,700.0 \text{ төг/м}^3 \times 0.2 \times 0.25 = 185.0 \text{ төг/м}^3$$

3,700.0 төг/м³: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;

20%: 326-р тогтоолын 4-т заасан авто замын зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь;

0.25: 327-р тогтоолд заасан Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт авто замын зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

$$2,292.0 \text{ м}^3 \times 185.0 \text{ төг/м}^3 = 424,020.0 \text{ төг}$$

Биологийн нөхөн сэргээлт хийх, мод тарихад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 3,700.0 \text{ төг/м}^3 \times 0.1 \times 0.2 = 74.0 \text{ төг/м}^3$$



3,700.0 төг/м³: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;

10%: 326-р тогтоолын 9-т заасан газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь;

0.2: 327-р тогтоолд заасан Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт ногоон байгууламжийн зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

$$1,140.0 \text{ м}^3 \times 74.0 \text{ төг/м}^3 = 84,360.0 \text{ төг}$$

Нийт төлбөр: 12,432,000.0 + 40,442.85 + 424,020.0 + 84,360.0 = 12,980,822.9 төг

/Арван хоёр сая есөн зуун наян мянга найман зуун хорин гурван төгрөг/.

17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар:

- Ахуйн хэрэгцээнээс гарсан бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах.

18. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө:

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй байх;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Үйл ажиллагаа зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж ажиллах;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт-шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах.



УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ДАРХАНЧИМЭГ

УС АШИГЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ч.ПУНЦАГСҮРЭН



УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/15

Сүмбэр сум

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын "Усны тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг "Усны газар"-ын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 87 тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах "Кевин инвест" ХХК-ийн хайлуур жонш олборлон, баяжуулах технологийн хэрэгцээнд 10'500.0 шоометр, унд ахуйн хэрэгцээнд 585.5 шоометр, зам талбайн тоосжилт дарах усалгаанд ашиглах 2'292.0 шоометр, биологийн нөхөн сэргээлт, мод тарихад 1'140.0 шоометр, эрчим хүч үйлдвэрлэлийн хэрэгцээнд 728.2 шоометр буюу нийт 14'660.2 шоометр усыг 1 жилийн хугацаагаар "Кевин инвест" ХХК-д ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. "Кевин инвест" ХХК-ийн ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавин ажиллахыг Газрын доорх усны нөөц, хяналт, шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн /О.Батхүү/-д үүрэг болгосугай.

3. Монгол Улсын "Улсын тэмдэгтийн хураамжийн тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.20-д заасны дагуу ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Даланжаргалан сумын Төрийн сан банкны дансанд тушаах, "Төсвийн тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг Дорноговь аймгийн төсөвт гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэхийг "Кевин инвест" ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Ванг Вей/-д үүрэг болгосугай.

4. "Усны тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны ашиглах боломжит нөөцийн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх болон "Усны тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2022 оны 12-р сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг "Кевин инвест" ХХК-ийн гүйцэтгэх захирал /Ванг Вей/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.САРАНТУЯА

БАТЛАВ.

УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

...../Б.САРАНТУЯА/



БАТЛАВ.

“КЕВИН ИНВЕСТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

...../БАНГ ВЕЙ/



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 05 сарын 18-ны өдөр

Дугаар- 13

Чойр хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ын гаргасан 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 87 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны даргын олгосон 2022 оны 05-дугаар сарын 18-ны өдрийн А/15 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н. Солонго, Ус ашиглагчийг төлөөлж: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Хилчний 40 тоот, 9019034023 улсын бүртгэлийн дугаартай, 5167663 регистрийн дугаартай “Кевин инвест” ХХК-ийн Үйлдвэрийн дарга Б.Батбаяр нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Хайлуур жонш баяжуулах үйлдвэр.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 14'660.2 м³/жил

2.2.1. Унд ахуйд: 585.0 м³/жил

2.2.2. Технологийн хэрэгцээнд: 10'500.0 м³/жил

2.2.3. Зам талбайн тоосжилт дарах: 2'292.0 м³/жил

2.2.4. Эрчим хүч үйлдвэрлэл: 728.2 м³/жил

2.2.5. Биологийн нөхөн сэргээлтэд: 960.0 м³/жил

2.2.6. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад: 180.0 м³/жил

2.4. Усны эх үүсвэр:

Унд ахуйн усыг Даланжаргалан сумын төвөөс зөөврөөр, технологийн хэрэгцээний усыг өөрийн эзэмшлийн баяжуулах үйлдвэрийн талбайд гаргасан 6 ш өрөмдмөл худгаас хангана. Манай үйлдвэрийн газрын 2020 оны 1/06 дугаар усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд хүрэлцээтэй гэсэн байна. Унд, ахуйд хоногт 16.1м³ ус ашиглана.

2.4.1. Байршил:

Дорноговь аймгийн Даланжаргалан сум

№	Уртраг	Өргөрөг	Ундарга (л/с)	Насосны марк	Тоолуурын	
					Марк	Дугаар
1	109 05 09	45 55 54	3.0 л/с	ЭЦВ-6-6.5-120	LXLC	202000928

2	109 05 49	45 55 19	4.8 л/с	ЭЦВ-6-10-185	202000929
3	109 05 20	45 55 31	3.0 л/с	ЭЦВ-6-6.5-12.0	202000919
4	109 05 28	45 55 43	3.2 л/с	ЭЦВ-6-10-185	202000933
5	109 05 23.60	45 55 48	4.2 л/с	ЭЦВ-6-10-185	202000912
6	109 05 22	45 55 57	4.0 л/с	ЭЦВ-6-10-185	202000902

2.4.2. Барилга байгууламж: Эргэлтийн усан сан 60.0 мян.м³ багтаажтай.

2.4.3. Тоног төхөөрөмжийн нэр, марк: Нийт ашиглалтын 6ш худгаас эргэлтийн усан сан руу 60мм голчтой, 929.0м урттай төмөр хоолойгоор ус татаж байна.

2.5. Хаягдал ус: Ахуйн бохир усыг бохирын септик системээр дамжуулан бохир хаягдлыг ялган задалж, ялгаран тунасан шингэн хэсгийг хөрсөөр дамжуулан бүрэн цэвэршүүлэн шүүж, халдваргүйжүүлдэг.

2021 онд тус үйлдвэр нь ахуйн бохир усыг Даланжаргалан сумын ОСНААҮГ-тай хамтран ажиллаж, 3 тн-ын багтаамжтай бохир усны зориулалтын машинаар 2 удаа соруулж зайлуулсан.

Хаях цэгийн байршил: Уурхай талбайд

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ:

Жинлэгдэх бодис, кг:.....
 Органик бодис, кг:.....
 Эрдэс бодис, кг:.....
 Хүнд металл, кг:.....
 Аюултай бохирдуулах бодис, гр:.....

2.7. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: -

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Усны тоолуур:

Булингын 2PNL маркийн 2ш, YX3-200L-4M маркийн хаягдлын 4ш, зутангийн 2ш динамик насостой. Эргэлтийн усны хоолойнуудад усны тоолуур суурилуулаагүй.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын дагуу уурхайн ажилчдын унд ахуйн хэрэгцээнд хэрэглэх 585.5 м³/жил усыг төлбөрөөс чөлөөлнө.

Ашигт малтмал олборлох, баяжуулах зориулалтаар ашиглах газрын доорх усны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3'700\text{төг/м}^3 \times 0.2 \times 1.6 = 1184\text{төг/м}^3$$

- 3'700төг/м³- Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:

- (20%)- Засгийн газрын 326-р тогтоолын 7(а) газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээ.

- 1.6 - Ашигт малтмал олборлох, баяжуулах зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$10'500.0 \text{ м}^3 \times 1184 \text{ төг/м}^3 = 12'432'000.0 \text{ төгрөг}$$

Эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглах газрын доорх усны төлбөр:

Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 327 дугаар тогтоолыг үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

$$1\text{м}^3 \text{ усны нөөц ашигласны төлбөр: } 3700\text{төг/м}^3 \times 0.15 \times 0.1 = 55.5\text{төг/м}^3$$

-3700төг/м³- Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ.

-(15%)- Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 8-д заасан хувь, хэмжээ.

-0.1- Эрчим хүчний үйлдвэрлэлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$$728.2\text{м}^3 \times 55.5\text{төг/м}^3 = 40'422.85 \text{ төгрөг}$$

Зам талбайн тоосжилт дарахад ашиглах газрын доорх усны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3'700\text{төг/м}^3 \times 0.2 \times 0.25 = 185.0\text{төг/м}^3$$

- 3'700төг/м³ Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:

- (20%)- Засгийн газрын 326-р тогтоолын 4-т заасан авто замын зориулалтаар тооцох газрын доорх усны хувь хэмжээ.

- 0.25- Авто замын зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$2'292.0\text{м}^3 \times 185.0\text{төг/м}^3 = 424'020.0 \text{ төг}$$

Биологийн нөхөн сэргээлт хийх, мод тарихад ашиглах газрын доорх усны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3'700\text{төг/м}^3 \times 0.1 \times 0.2 = 74\text{төг/м}^3$$

- 3'700төг/м³- Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:

- (10%)- Засгийн газрын 326-р тогтоолын 9 заасан нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд тооцох газрын доорх усны хувь хэмжээ.

- 0.2- Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$1'140 \text{ м}^3 \times 74 \text{ төг/м}^3 = 84'360.0 \text{ төг}$$

$$\text{Нийт төлбөр} = 12'432'000.0 + 40'422.85 + 424'020.0 + 84'360.0 = 12'980'822.9 \text{ төгрөг}$$

/Арван хоёр сая есөн зуун наян мянга найман зуун хорин хоёр төгрөг есөн мөнгө/

Уурхайн технологийн хэрэгцээ болон зам талбайн тоосжилт дарах, биологийн нөхөн сэргээлт, эрчим хүчний зориулалтаар ашиглах **14'660.2 м³/жил** газрын доорх усны төлбөр **12'980'822.9 төгрөг** / Арван хоёр сая есөн зуун наян мянга найман зуун хорин хоёр төгрөг есөн мөнгө/ **Дорноговь аймгийн Төрийн сан банкны 060000944 тоот дансанд төвлөрүүлнэ.**

Усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлсөн мэдээ, ус ашиглалтын тайланг 2022 оны 12 сарын 15-ны дотор гаргаж ирүүлнэ.

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1. Ус ашиглуулагч нь "Усны тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.9, 17.1.10 дахь заалтын дагуу эрх эдэлнэ.

3.2. Ус ашиглагч нь дараах үүрэгтэй:

3.2.1. "Усны тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын дагуу ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;

3.2.2. "Усны тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулна.

3.2.3. "Усны тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг сав газрын захиргаанд гаргаж өгнө.

3.2.4. Ус ашиглалтын байдалтай холбоотой асуудлыг тухай бүрт нь мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд сав газрын захиргааны холбогдох мэргэжилтнийг дуудаж газар дээр нь шийдвэрлэж байх;

3.2.5. Ажилчдын ундны усыг стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангаж улирал тутам итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулж 1 хувийг Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.6. Хаягдал бохир усанд биохимийн шинжилгээг улирал тутамд 1 удаа хийлгэж шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган сав газрын захиргаанд ирүүлнэ.

3.2.7. "Усны тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.2.3, 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтуудын дагуу аж ахуй нэгж байгууллага нь газрын доорх усны дотоод хяналтын цэгийг байгуулна.

3.2.8. Тухайн сумын татварын болон байгаль орчны хяналтын улсын байцаагчдыг тус тус байлцуулан тоолуурын заалтыг сар бүрийн эхний болон эцсийн заалтыг акт, зургаар баталгаажуулалт хийж 1 хувийг СГЗ-нд ирүүлэх.

3.2.9. Үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар зогсолт хийх, эргэн ажиллах бол тухай бүрт нь мэдэгдэж албан тоот ирүүлэх;

3.2.10. Усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар, буюу хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаа нуун дарагдуулсан, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, усны төлбөр төлөхөөс зайлсхийсэн болон ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд "Зөрчлийн тухай" хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2022 оны 12 дугаар сарын 15-ны дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд, нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг "Усны тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтууд болон дор дурьдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцална.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.


4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

...../Н. Солонго/

Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, 3-р байр, 5-р орц, 66 тоот

Харилцах утас: 7054-3598, 7054-3599

Ус ашиглагчийг төлөөлж:

"Талст дөл" ХХК-ийн үйлдвэрийн

дарга

...../Б.Батбаяр/

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Хилчний 40 тоот,

Харилцах утас: 8808-6411



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,
Чингүнжавын гудамж, Утас/Факс: (976-51) 26 55 78,
И-мэйл: contact@mwa.mn

2022. 03. 01 № 06/179

танай 2022. 02. 07 ны № Т/01 -т

“КЕВИН ИНВЕСТ” ХХК-Д

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, танай компанийн 2022 оны Т/01 тоот “Хаягдал усны дүгнэлт гаргуулах тухай” хүсэлт, БОАЖ-ын Сайд, БХБ-ын Сайдын хамтарсан 2019 оны А-816/218 тоот тушаалаар батлагдсан “Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ”-г тус тус үндэслэн 2021 оны хаягдал усны дүгнэлтийг гаргаж, ус бохирдуулсны төлбөрийг тооцон хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанд.

Хавсралт хуудастай.

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛБЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА  Я.БОЛДБААТАР



16322045

ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2022 оны 03 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот
Утас:265528, 265578

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

- Компанийн нэр: "Кевин-Инвест" ХХК
- Захирал: Ванг Вей
- Холбоо барих утасны дугаар: 99807676
- Компанийн улсын бүртгэлийн дугаар: 9019034023
- Регистрийн дугаар: 5167663

1.2. Төслийн нэр, байршил

"Кевин-Инвест" ХХК-ийн жонш баяжуулах үйлдвэр нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын төвөөс зүүн хойш 2км, Сайншанд хотоос баруун хойш 156 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 305 км, Говьсүмбэр аймгийн Чойр хотоос зүүн урагш 75 км-ийн зайд байрлана. Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарч байна.

Хоёр. Хаягдал усны талаарх мэдээлэл

22.1. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин:

"Кевин-Инвест"-ийн хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь унд ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг септик танкийн тусламжтайгаар 2 шатны цэвэрлэгээг хийн байгальд нийлүүлдэг бөгөөд цэвэрлэсэн ахуйн бохир усыг үйлдвэрийн орчны зам талбайн тоосжилт дарах болон ногоон байгууламжийн усалгаанд ашигладаг байна. Технологийн хаягдал усыг 367'000 м³ эзлэхүүнтэй хаягдлын санг ашиглан механик аргаар цэвэрлэж, баяжуулах үйлдвэрт эргүүлэн ашигладаг ба үлдсэн хэсгийг байгальд нийлүүлдэг байна.

2.2. Хаягдал усны хэмжээ:

Тус компанийн унд ахуйн хаягдал усны хэмжээг тоолуурын заалт /гүйцэтгэл/-аар 4'333.5 м³/жил, технологийн хэрэгцээнээс гарсан хаягдал усны хэмжээг нөхөн сэлбэлтээр авч ашигласан ус, шавхан зайлуулсан усны хэмжээгээр 114'733.5 м³/жил, уурын зууханд ашигласан хаягдал усны хэмжээг 728.2 м³/жил байхаар тус тус тооцов.

2.3. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2019 оны А-816/218 тоот тушаалаар батлагдсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-г үндэслэн унд ахуйн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг Органик бодис /химийн хэрэгцээт хүчилтөрөгч/-ын хэмжээг ажилчдын тосгон 1.5 кг/м³-ээр үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашигласан хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг бусад үйлдвэрлэл, үйлчилгээнд 0.8 кг/м³-ээр тус тус тооцов.

Гурав. Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ

3.1. .1. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ, БОАЖ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан 2019 оны А-816/218 тоот тушаалаар батлагдсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-г үндэслэн унд ахуйн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг Органик бодис /химийн хэрэгцээт хүчилтөрөгч/-ын хэмжээ ажилчдын тосгон 1.5 кг/м³-ээр, технологийн хэрэгцээнээс гарсан хаягдал ус, шавхан зайлуулсан хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг бусад үйлдвэрлэл, үйлчилгээ 0.8 кг/м³, уурын зуухны ашиглалт үйлчилгээнээс гарсан хаягдал усан

дахь бохирдуулах бодисын хэмжээг эрчим хүч, дулааны үйлдвэрлэл 0.4 кг/м^3 -ээр -ыг тус тус үндэслэн тооцоход:

3.2. Ус бохирдуулсны төлбөрийн тооцоо;

3.2.1. Органик бодис /XXX/: $1.5 \text{ кг/м}^3 * 4'333.5 \text{ м}^3 * 50 \text{ төг/кг} + 0.8 \text{ кг/м}^3 * 114'733.5 \text{ м}^3 * 50 \text{ төг/кг} + 0.4 \text{ кг/м}^3 * 728.5 \text{ м}^3 * 50 \text{ төг/кг} = 325'012.5 + 4'589'340.0 + 14'570.0 = 4'928'922.5$
/Дөрвөн сая есөн зуун хорин найман мянга есөн зуун хорин хоёр төгрөг таван мөнгө/ төгрөг ногдож байна.

3.3. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасны дагуу гуравдугаар хавсралтын дагуу тооцсон эргүүлэн ашигласан усны төлбөр болох $16'366'550.4$ төгрөгийг 100% чөлөөлөв.

Дөрөв. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж

4.1. Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг авах;

4.2. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13 дахь хэсэгт заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаатай "Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ" байгуулах;

4.3. БОНХ-ийн Сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дахь заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах;

4.4. "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын шаардлагыг хангасан хаягдал усыг байгальд нийлүүлэх, стандартаас давсан бол Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах;

4.5. Хаягдал усны дүгнэлтийг жил бүрийн эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор ирүүлж байх;

4.6. Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлөх ба хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарах;

4.7 Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг, хаягдал усны шинжилгээний дүнгүүд, төлбөр төлсөн баримтыг Усны газрын office@water.gov.mn цахим хаягаар 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б.АМАРТАЙВАН



БАТЛАВ

УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ - ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
1 15 САРАНТУЯА

БАТЛАВ

"КЕВИН ИНВЕСТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ ВАНГ ВЕЙ
ИНВЕСТ
ХХК

**ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН
ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ**

20~~22~~ оны 03 сарын 24 ны өдөр

Дугаар 04

Чойр

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын Сав газрын захиргааны гаргасан 20~~22~~ оны 03 дугаар сарын 08-ний өдрийн 04 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Умард говийн гүвээт-Халхын дундад талын Сав газрын захиргааны Усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Нэргүй овогтой Солонго,

Нөгөө талаас: Ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Хилчний гудамж, 40 тоотод байрлах 9019034023 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 5167663 тоот регистрийн дугаартай хуулийн этгээдийг төлөөлж "Кевин Инвест" ХХК-ны үйлдвэрийн дарга Б.Батбаяр нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

Ус бохирдуулсны төлбөрийн нийт дүн: 4'928'922.5 төгрөг /Дөрвөн сая есөн зуун хорин найман мянга есөн зуун хорин хоёр төгрөг таван мөнгө/ хаягдал усны дүгнэлт үндэслэв.

2.3. Төлбөр төлөгч нь.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист

ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах Татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа Татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1.Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.4.2.Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.3.Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.4.Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.4.5.Бохирдуулах бодисын ялгарал шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.4.6.Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17.1.8 дахь хэсэгт заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно;

3.3.Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4.Сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Умард говийн гүвээт-Халхын
дундад талын сав газрын захиргааны
Усны чанар экологи, төлбөрийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

Н. Солонго



Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг,
Сүмбэр сум, 3-р баг, 3-р байр
Харилцах утас: 7054-3598
Факс: 976-7054-3599

Ус ашиглагчийг төлөөлж:

"Кевин Инвест" ХХК-ийн
үйлдвэрийн дарга
Б. Батбаяр



Хаяг: Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 8-р хороо,
Хилчний гудамж, 40 тоотод
Харилцах утас: 8808-6411

**"Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг
сэргээн засварлах, шинээр гаргах эзэмших,
ашиглах журам"-ын 1 дүгээр хавсралт**

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАЛАНЖАРГАЛАН СУМ
АЖЛЫН ХЭСГИЙН АКТ**

2022 оны 5 сарын 18 өдөр

**Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг
шинээр гаргасан тухай**

1.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн (овог нэр, албан тушаалыг тодорхой бичнэ)
а/Ажлын хэсгийн ахлагч: Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын
орлогч Э.Сүхбаатар

б/ Гишүүд: нийлүүлэгч "Талст дөл" ХХКомпаний баяжуулах үйлдвэрийн дарга
Б.Батбаяр

гүйцэтгэгч "Эхний эхэн" ХХКомпаний өрмийн мастер С.Мөнх-Эрдэнэ

Захиалагчийн төлөөлөгч: Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГазар

Өмчлөгчийн төлөөлөгч: Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГазар

Усны мэргэжлийн байгууллагын төлөөлөгч "Эхний Эхэн" ХХКомпани

Төсөл, хөтөлбөрийн санхүүжүүлэгч: "Талс дөл" ХХКомпани

2.Худаг, уст цэгийн байршил сум, газрын нэр: Дорноговь аймгийн Даланжаргалан
сумын Цомог 4-р баг

3.Өмчлөл, эзэмшлийн байдал: "Тэрбум мод" хөтөлбөрийн усжуулалт

4.Инженерийн хийцтэй худаг, уст цэгийн нэр, төрөл: Дорноговь аймгийн
Даланжаргалан сумын Цомог 4-р баг мод усалгааны газар

5.Урьд нь улсын болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр сэргээн засварлалт
хийгдсэн эсэх: Үгүй

6.Худгийн үзүүлэлт"

1-р худгийн улсын дугаар 001, худгийн координат уртраг N45°55'383 өргөрөг
E109°20'933, худгийн гүн 70 м, ундарга 1,5 л/с, статик түвшин 21 м, динамик түвшин
54 м, тоног төхөөрөмжийн марк: насос:1,5квт,

2-р худгийн улсын дугаар . 002 ., худгийн координат уртраг N N45°55'283
өргөрөг E E109°34'670, худгийн гүн 70 м, ундарга 1,5 л/с, статик түвшин 24 м,
динамик түвшин 55 м, тоног төхөөрөмжийн марк: насос:1,5квт,

7. Ашиглалтад өгсөн: 2022 он 05.18 , 2 худгийн одоогийн үнэ 30.000.000 төгрөг.

8.сэргээн засварлах, шинээр гаргах ажлын төрөл, хэмжээ /ямар

төрлийн, хэдийн хэмжээний ажил хийхийг тодорхой бичих/ : Цооног өрөмдөж, тоноглож, насос суулгаж, битүүмжлэн цооногийг угааж, шавхалт хийсэн.

9.Сэргээн засварлах, шинээр гаргах ажлын талаарх өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн санал: Худгийг хүлээн авч ашиглалтанд оруулж Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГазрын эзэмшилд хүлээлгэн өгөв.

10.Эхлүүлэх хугацаа 2022 он 5 сар 01 өдөр, дуусгах 2022 он 5 сар 20 өдөр

11.Сэргээн засварлах, шинээр худаг гаргах ажлын өртгийн хэмжээ 30.000.000 төг.

Үүнээс "Талст дөл" ХХКомпаний хөрөнгө оруулалт 30.000.000 төг

12.Тусгай тэмдэглэл /сэргээн засварлах, шинээр худаг гаргасны үр дүн гэх мэт/ Инженерийн хийцтэй 2 худаг нь техникийн тодорхойлолтын дагуу бүрэн хийгдсэн тул ашиглалтанд хүлээн авав.

ГЭРЭЭТ АЖЛЫГ

ХҮЛЭЭН АВСАН:

ЗАХИАЛАГЧ
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОН

..... Э.СҮХБААТАР

"ТАЛСТ ДӨЛ" ХХКОМПАНИЙ
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ДАРГА

..... Б.БАТБАЯР

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

ГҮЙЦЭТГЭГЧ
"ЭХНИЙ ЭХЭН"ХХКОМПАНИЙ
ӨРМИЙН МАСТЕР

..... С.МӨНХЭРДЭНЭ

Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авсан акт

2022 оны 10 сарын 28 өдөр

№.....

№	Асуулт	Хариулт
1	Байршил: Аймаг, сум, баг, газрын нэр:	Дорноговь аймаг Даланжаргалан сум Бичигт баг
2	Аж ахуйн нэгжийн нэр: Хаяг: Холбоо барих утас: И-майл хаяг: Аж ахуйн нэгжийн Гэрчилгээний дугаар: Регистриин дугаар:	"Талст дөл" ХХК Бичигт баг 99096800 Talstdol.6800@gmail.com 9011048033 РД:5105439
3	Тусгай зөвшөөрлийн дугаар: Ордын нэр: Талбайн хэмжээ /га/	
4	Нөхөн сэргээлтийг хүлээлгэн өгсөн: "Талст дөл" ХХК Албан тушаалын нэр: Овог, нэр: Утас: И-майл хаяг:	Үйлдвэрийн дарга Б.Батбаяр 88086411
5	Нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь хэмжиж зураглал үйлдсэн мэргэжлийн байгууллагын нэр: Хаяг:	
6	Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, чанар:	1,7 га газар техникийн нөхөн сэргээлт
7	Нэг. Нөхөн сэргээлтийн хэмжээ: 1.1 Техникийн нөхөн сэргээлт Талбайн хэмжээ га-аар Ажлын хэмжээ м.куб-ээр Зардал төгрөгөөр 1.2 Биологийн нөхөн сэргээлт Талбайн хэмжээ га-аар Тарьсан мод, бут, сөөг ургамал /төрлөөр/ Ургалтын хувь Зардал төгрөгөөр	1,7 га газар 8985,5 м.куб 25,010,000 төгрөг
8	Хоёр. Нэмэлт мэдээлэл /Том масштабын /1:1000, 1:2000 гм/ зураглал, фото зураг, шинжилгээний дүн, хүлээлгэн өгсний дараах мониторинг зардлын санхүүгийн	

Нөхөн сэргээлтийн ажлын дүгнэлт:

“Талст дөл” ХХК нь Даланжаргалан сумын Бичиг багт бичил уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, эзэнгүй орхигдсон газарт 1,7га талбайг эрүүлжүүлэх зорилгоор техникийн нөхөн сэргээлт хийж ажилласан.

ДГА-ийн БОАЖГ-аас санал хүргүүлсэн Дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлтийн 2 цэгээс гадна дээрх цэгүүдтэй ойр орших 5 тооны жижиг хэмжээтэй 0,2 га газарт нөхөн сэргээлтийн хийж ажиллаа.

Тайлбар: /нөхөн сэргээлтэд хамрагдсан талбай, хийсэн ажлын хэмжээг техникийн болон биологийн гэж ангилан хэмжилтийн дүнг үндэслэн тогтооно. Биологийн нөхөн сэргээлтэд ашигласан бут, ургамлын төрөл зүйлийг тодорхой тусгана/

АКТ ГАРГАСАН:

Комиссын дарга:
/тамга

Гишүүд


ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

“Талст дөл” ХХК
/аж ахуйн нэгжийн нэр/

Огноо


/гарын үсэг/

/гарын үсэг/


/ нэр, албан тушаал/


/ нэр, албан тушаал/

Үйлдвэрийн дарга
/Б.Батбаяр/
/ нэр, албан тушаал/